

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан богд хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Даланзадгад хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 48083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 226
танай _____-ны № _____-т

ХАНБОГД СУМЫН ХАНБОГД
ХОТ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ЭРХЭМБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын Ханбогд Хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын Ханбогд Хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулаагүй зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалттай тус тус нийцээгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ханбогд Хот тохижилт ОНӨААТҮГ нь 2015 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй барилгыг тавилга хэрэгслийн хамт ашиглаж байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг сумын Засаг дарга баталж байна. Тус байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөлгүйгээр 2022 онд үйл ажиллагаагаа явуулжээ.

016020307

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	428.4	427.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	823.2	1,038.9
Нийт хөрөнгийн дүн	1,251.6	1,466.4
Нийт өр төлбөрийн дүн	321.3	812.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	930.3	653.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,251.6	1,466.4
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн	534.1	585.3
Үйл ажиллагааны зардал болон ББӨ-н дүн	676.2	592.8
Татварын өмнөх ашиг	(142.1)	(7.5)
Татварын дүн	-	
Татварын дараах ашиг	(142.1)	(7.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	825.3	683.2
Хуримтлагдсан ашиг	(142.1)	(29.5)
Эцсийн үлдэгдэл	683.2	653.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	829.3	576.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	851.6	638.5
Үйл ажиллагааны ЦМГ	(22.3)	(62.1)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(87.8)	(0.6)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(110.1)	(62.7)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	219.5	109.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	109.3	46.1
Зорилтот түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт борлуулалтын орлого	649.5	575.6
Үйл ажиллагааны зардал	617.4	605.4
Үйл ажиллагааны бус зардал	-	-
Нийт зардал	617.4	605.4
Татвар төлөхийн өмнөх ашиг	32.1	(29.8)
Татвар	3.2	-
Татварын дараах ашиг	28.9	(29.8)

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 397.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 397.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Үнэ төлбөргүй ирсэн 395.0 сая төгрөгийн хөрөнгийг хойшлогдсон орлого дансанд залруулсан, мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 2.0 сая төгрөгөөр илүү илэрхийлснийг залрууллаа.

Аудитаар нийт 691.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага 1 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

3.2.1 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 331.0 сая төгрөгийн авлага, 23.3 сая төгрөгийн урьдчилгааг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй өмнөх аудитаар өгөгдсөн авлагыг барагдуулан ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан ажиллаж авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгууллагын нягтлан бодогчид Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллах

3.2.2 Өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 337.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өглөгийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй өмнөх аудитаар өгөгдсөн авлагыг барагдуулан ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан ажиллаж өглөгийг барагдуулах ажлыг зохион байгуулж аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгууллагын нягтлан бодогчид Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллах

3.2.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 151 мэдээлэл мэдээлэхээс 136 мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хугацаа болоогүй байгаа тул мэдээлээгүй, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэрэгжилтийг нь ханган ажиллах. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй нягтлан бодогчид Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллах

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тооцохыг батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж хууль, стандарт, дүрэм, журам, зааварт өөрчлөлт орсон тухай бүрд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулан баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд зөрүүтэй тусгасан	1	395,043.6			1	395,043.6	1	395,043.6				
Орлогыг илүү илэрхийлсэн	1	1,980.0			1	1,980.0	1	1,980.0				
Дүн	2	397,023.6			2	397,023.6	2	397,023.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	/мянган төгрөгөөр/
--	--------------------

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НБББББ-ийг шинэчлэн батлаагүй	1						1					
Авлагын бүртгэл	1	354,318.4							1	1		
Өглөгийн бүртгэл	1	337,292.3							1	1		
Дүн	3	691,610.7					1		2	2		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1				1			

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨОНААТҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		